

**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-ААС АЛБАН ХААГЧДЫН САХИЛГА
ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД 2022 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны 12 дугаар сарын 09			Улаанбаатар хот	
№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЕЛЭЛТ	Хувь	
		НЭГ. САХИЛГА ХАРИУЦЛАГА, ЁС ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР		
1.	Байгууллагын “Ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах,	Байгууллагын Ёс зүйн зөвлөлийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/09 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. 2022 оны байдлаар байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчил гаргасан талаар өргөдөл гомдол Ёс зүйн зөвлөлд ирээгүй байна.	80	
2.	Ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах, гарсан шийдвэрийг ил тод болгох;	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, байгууллагын даргын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/07 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Албан хаагчдад байгууллагын шинэчлэн баталсан Хөдөлмөрийн дотоод журмыг танилцуулж, мөрдөж ажиллах, ёс зүйн аливаа зөрчил гаргахгүй ажиллах талаар үүрэг болгосон.	80	
3.	Ажилтнуудын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар тодорхой ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах	Ажилтан нэг бүрийн цаг ашиглалтын бүртгэлийг ERP системийн цаг бүртгэлийн системээр бүртгэн, цагийн бүртгэлд удирдлага болон хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн хяналт тавин ажиллаж байна.	80	
4.	Дээд шатны байгууллагаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд албан хаагчдыг идэвхтэй оролцуулах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Цагдаагийн байгууллагагай хамтран “Намайг алгас” нөлөөллийн аяныг улсын хэмжээнд зохион байгуулж байгаатай холбогдуулан байгууллагын нийт албан хаагчдыг тус аянд хамруулсан. Энэ ажлын хүрээнд хамт олон, найз нөхдийн архивалт, согтууруулах ундааны хэрэглээ, буруу үзэгдэл, үйл явдлаас залуу үеийг татгалзуулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бүх нийтэд хэрэглээний зөв соёл, хандлага, сонголтыг нэвтрүүлэх зорилгоор “Хүлээх хүнтэй” уриан доор нэгдэж, ERP системийн мэдээлэл хэсэгт байршуулж ажилласан.	100	

ХОЁР. ТӨСВИЙН САХИЛГА БАТЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР		
5.	Байгууллагын санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж нягтлан бодох бүртгэлийн болон улсын стандарт, УИХ, Засгийн газар, Сангийн сайдын баталсан холбогдох заавар журмыг мөрдөж ажиллах;	Санхүүгийн үйл ажиллагаанд анхан шатны баримтын бүрдлийг нягтлан шалган өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэн ажиллаж байна.
6.	Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, захиран зарцуулалтанд хяналт тавих, дотоод хяналтыг сайжруулах;	Тайлант жилд хөрөнгийн тооллогыг цаг тухайд нь явуулж тайлан мэдээг хавсаргаж ирсэн. Хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах тал дээр тоног төхөөрөмжийн агуулахад тоног төхөөрөмжийг зөв байршуулах, техник тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд хяналт тавьж ажилласан. Фермийн талбайд байрлуулсан хяналтын камерын засвар үйлчилгээг хийлгэн бүрэн ажиллагаанд оруулсан. Нийслэл орчмоос алслагдсан дүүрэгт байрладаг тул болзошгүй гэнэтийн осол аваараас сэргийлэн эд хөрөнгө, Тээврийн хэрэгслийн даатгалд бүрэн хамруулсан.
7.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, нийслэлийн хэмжээнд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг богиносгох, зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцуулан, зохих байгууллага албан тушаалтанд мэдээлж байх;	2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын хэмжээнд 4 өргөдөл, хүсэлт ирсэн. Ирсэн өргөдөл, гомдлыг цаасаар хүлээн авч, ERP системийн өргөдөл гомдлын дэд системд тухай бүрд нь бүртгэн оруулж, удирдлагад танилцуулж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэсэн.
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР		
		80
		70
		81%

ТАНИЛЦСАН:

ДАРГА

ХЯНАСАН:

ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ

ХЭРГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Н.УУГАНБАЯР

Г.ПҮРЭВСҮРЭН

Б.ОТГОНЖАРГАЛ

